



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1/290

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралт ёсоор олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Ахуйн шавьж мэргэч устгах, халдваргүйжүүлэлт, үйлчилгээ MNS5161-3:2002, Сувилалын бүтэц, үйл ажиллагаа MNS5232:2013, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 болон өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс /Ц.Эрдэнэсүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ ЭРДЭНЭ



02000000